



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 3,140,860.00 (гурван сая нэг зуун дөчин мянга найман зуун жаран) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Сангийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, "Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Б.Ундрям нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлтэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайландаа тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

3. МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



000002!

Төрийн өмчийн борлуулга, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн
35 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР" ТӨРИЙН ӨМЧИЙН АЖАХУЙН
ТООЦООТОЙ ҮЙЛДВЭРНИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГОД БҮРТГЭЛТЭЙ САНГИЙН ЯАМАНД
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУУЛЭХ ХӨРӨНГӨ

Д/Д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бурийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хурийтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо)	2019	M2	97	3,140,860.00	3,140,860.00		3,140,860.00
	Нийт дүн					3,140,860.00 (Гурван сая нэг зуун дөчин мянга найман зуун жаран)		3,140,860.00 (Гурван сая нэг зуун дөчин мянга найман зуун жаран)